



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/739

Булган сум

Аймгийн 2025 оны шинэ жилийн баярын
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны “Шинэ жил”-ийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Булган сумын Цогт Хунтайжийн талбайн чимэглэл, тохижилтын ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д даалгасугай.

3.Байгууллагын гадна гэрлэн чимэглэл хийж, өнгө үзэмжийг нэмэгдүүлэхэд идэвх, санаачилгатай оролцохыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


4.Аймгийн “Шинэ жил”-ийн баярын бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, зохион байгуулалтад хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



11 Аймгийн Засаг даргын 2025 оны
... дүгээр сарын ... ны/ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт



Аймгийн нэгдсэн шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:
- Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
 - Б.Насанжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 - М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
 - Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
 - Э.Эрболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан)
 - С.Батнасан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)
 - Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга)
 - Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
 - Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
 - Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
 - Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
 - С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
 - О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
 - Э.Манлайбаатар (Аймгийн залуучуудын холбооны тэргүүн)
- Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)